



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 474

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой, 9 нэрийн, нийт 94,044,650.00 (ерэн дөрвөн сая дөчин дөрвөн мянга зургаан зуун тавь) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 21,428,930.00 (хорин нэгэн сая дөрвөн зуун хорин найман мянга есөн зуун гуч) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Нарийн бичгийн дарга Г.Төгөлдөрт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132002301

22-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 18 дугаар сарын 18 ны/ний өдрийн
11:33 дугаар тогтоолын хавсралт

ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТЭЛТЭЙ,
АШИГЛАХ ХУГАЦАА, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Нэгж балансын үнэ (төгрөг)	Нийт балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоох хугацаа (жил)	Цаашид шинэчлэн тогтоох нэг бүрийн үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон нийт үнэ (төгрөг)
1	NISSAN. Teana-L-33, улсын угаар 2095УАО, Арлын дугаар 1N4AL3AP7EC297997	2022-09-14	1	79,741,650.00	79,741,650.00	3	15,948,330.00	15,948,330.00
2	Бичгийн төмөр шкаф YLB-A08	2012-06-30	2	310,000.00	620,000.00	3	124,000.00	248,000.00
3	Бичгийн төмөр шкаф 3 хаалгатай	2012-06-30	5	330,000.00	1,650,000.00	3	330,000.00	1,650,000.00
4	Бичгийн төмөр шкаф YLB-A25	2012-06-30	1	290,000.00	290,000.00	3	58,000.00	58,000.00
5	Цайны шүүгээ	2013-03-30	2	210,000.00	420,000.00	3	84,000.00	168,000.00
6	Цайны ширээ	2013-03-30	4	180,000.00	720,000.00	3	144,000.00	576,000.00
7	Номын төмөр шкап	2014-09-30	4	275,000.00	1,100,000.00	3	220,000.00	880,000.00
8	Д1 буйдан, ширээ	2016-07-08	1	1,593,000.00	1,593,000.00	3	318,600.00	318,600.00
9	Вейб сайт	2019-06-30	1	7,910,000.00	7,910,000.00	3	1,582,000.00	1,582,000.00
				90,839,650.0	94,044,650.00			21,428,930.00
ДҮН				(ерэн дөрвөн сая дөчин дөрвөн мянга зургаан зуун тавь)				(хорин нэгэн сая дөрвөн зуун хорин найман мянга есөн зуун гуч)